



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/352

Хэрлэн сум

Мөнгөн тэтгэмж олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9, Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын сайдын 2023 оны 5 дугаар сарын 22-ны 1/1359 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн соёлын байгууллагын ажилчдад мөнгөн тэтгэмж олгох журам батлагдсаны дагуу соёлын байгууллагад ТҮСУ шатлалаар тасралтгүй 5-аас дээш жил ажилласан албан хаагчдад 6 сарын цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмжийг олгосугай.

2. Дээрх журмын шаардлага хангасан ажилтан албан хаагчдад шаардагдах мөнгөн хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Тэтгэмжид зарцуулагдах зардлыг тухайн байгууллагуудын тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ